


“МХБ” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2015 оны  
12 дугаар сарын 30-ны өдрийн ~~25/19~~ дугаар  
тогтоолын гуравдугаар хавсралт



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
“ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ”

000075

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1 дүгээр зүйл. Журмын зорилго
- 2 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ
- 3 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тайлбар

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛ

- 4 дүгээр зүйл. Хяналт шалгалтын ажлын чиглэл
- 5 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааны хяналт шалгалт
- 6 дугаар зүйл. Гишүүн үнэт цаасны компанид тавих хяналт шалгалт
- 7 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчид тавих хяналт шалгалт
- 8 дугаар зүйл. Өргөдөл гомдол, мэдээ мэдээлэлд үндэслэсэн хяналт шалгалт

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ

- 9 дүгээр зүйл. Хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт, тайлан мэдээ

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

- 10 дугаар зүйл. Хяналт шалгалтын мэргэжилтэн, Хамтарсан ажлын хэсгийн эрх
- 11 дүгээр зүйл. Хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүний үүрэг
- 12 дугаар зүйл. Хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүдэд хориглох үйл ажиллагаа

### ТАВДУГААР БҮЛЭГ. ЗӨРЧИЛ, ТҮҮНД НОГДУУЛАХ ХАРИУЦЛАГА

- 13 дугаар зүйл. Зөрчлийн төрлүүд
- 14 дугаар зүйл. Хүлээлгэх хариуцлага

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаасны арилжаа, гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, зохих шалгалтыг хийх, хариуцлага ногдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

2.1. “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/-ийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэр, үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компаниаг байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжинэ.

2.2. Энэхүү журам нь гадаад, дотоодын хуулийн этгээдэд нэгэн адил үйлчилнэ.

### 3 дугаар зүйл. Журамд орсон нэр томъёоны тайлбар

3.1. Энэхүү журамд тусгагдсан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

3.1.1. “Гишүүн үнэт цаасны компани” гэж “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 24.1.1, 24.1.2-д заасан, Биржийн гишүүний эрх авсан хуулийн этгээдийг;

3.1.2. “Мэргэжлийн оролцогч” гэж “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын дагуу эрх авсан этгээдийг;

3.1.3. “Бусад оролцогч” гэж хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч зэрэг гишүүн үнэт цаасны компаниас бусад үнэт цаасны зах зээлд оролцогчийг;

3.1.4. “Эрх бүхий этгээд” гэж Биржийн ТУЗ, Гүйцэтгэх захирал, Хяналт шалгалт хариуцсан нэгжийн удирдлага, Хорооны улсын байцаагч;

3.1.5. “Хяналт шалгалтын мэргэжилтэн” гэж Биржийн гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн холбогдох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, үнэт цаасны арилжааны явц, үнэ ханшийн өөрчлөлтийг хянах эрх бүхий Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгжийн мэргэжилтнийг;

3.1.6. “Хяналт шалгалт хариуцсан нэгж” гэж Биржийн гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн холбогдох үйл ажиллагаа, үнэт

цаасны арилжаанд хяналт, шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлэгч Биржийн зохион байгуулалтын нэгжийг;

- 3.1.7. “Хамтарсан ажлын хэсэг” гэж Бирж болон Хорооноос томилогдсон гишүүдээс бүрдсэн төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, энэ журам, бусад хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулах эрх бүхий бүрэлдэхүүн;
- 3.1.8. “Гэрээ” гэж Биржээс Гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээг;
- 3.1.9. “Хяналт шалгалт” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.5, 70.1.6, 70.1.9-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх, алдаа дутагдлыг илрүүлэх, засч сайжруулах, хариуцлага ногдуулахад чиглэсэн үйл ажиллагаа;
- 3.1.11. “Ерөнхий хяналт” гэж үнэт цаасны арилжааны явцыг хяналтын системийн тусгай програмаар хянахыг;
- 3.1.12. “Нарийвчилсан шалгалт” гэж ерөнхий хяналтын явцад илэрсэн сэжиг бүхий хэлцэл болон үнэт цаасны арилжаа, үнэ ханштай холбоотой мэдээ мэдээллийн дагуу хийгдэх шалгалтыг;
- 3.1.13. “Төлөвлөгөөт шалгалт” гэж тогтоосон хуваарийн дагуу тодорхой цаг хугацааны давтамжтайгаар гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хийх шалгалтыг;
- 3.1.14. “Гэнэтийн шалгалт” гэж иргэдийн мэдээлэл, өргөдөл гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээ, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, арилжаа, гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг алсаас хянах явцад илэрсэн зөрчил зэрэг цаг үеийн шаардлагаар гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хийх шалгалтыг;
- 3.1.15. “Сэрэмжлүүлэх дохио” гэж хяналтын системийн тусгай програмаар тодорхойлсон сэжигтэй хэлцлийг;
- 3.1.16. “Сэжиг бүхий хэлцэл” гэж үнэт цаасны үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо хэмжээ зэргийг үндэслэн Хяналт шалгалт хариуцсан нэгжээс тодорхойлсон зөрчилтэй байж болзошгүй хэлцлийг;
- 3.1.17. “Анхан шатны баримт” гэж үнэт цаасны арилжаа, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтыг;

- 3.1.18. “Албан даалгавар” гэж Хяналт шалгалт хариуцсан нэгжээс гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчдад хугацаатай үүрэг даалгавар өгч хүргүүлсэн баримт бичгийг;
- 3.1.19 “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэж радио, телевиз, сонин, сэтгүүл, цахим хэвлэлийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛ

### 4 дүгээр зүйл. Хяналт шалгалтын чиглэл

- 4.1. Хяналт шалгалтыг дараах чиглэлээр явуулна:
  - 4.1.1. үнэт цаасны арилжааны хяналт шалгалт;
  - 4.1.2. Гишүүн үнэт цаасны компанид тавих хяналт шалгалт;
  - 4.1.3. Үнэт цаас гаргагчид тавих хяналт шалгалт;
  - 4.1.4. өргөдөл гомдол, мэдээ мэдээлэлд үндэслэсэн хяналт шалгалт.

### 5 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааны хяналт шалгалт

- 5.1. Хяналт шалгалт хариуцсан нэгж нь арилжааны хяналтын програмыг ашиглан өдөр бүрийн үнэт цаасны арилжааны явцад дараах ерөнхий хяналт тавьж, нарийвчилсан шалгалт хийнэ:
  - 5.1.1. өдөр тутмын үнэт цаасны арилжааны явцад хувьцааны ханш хэт өссөн, хэт буурсан, цөөн тоо ширхэгээр, эсхүл их хэмжээгээр удаа дараа арилжигдсан зэрэг хяналтын програмаар үүссэн сэжиг бүхий хэлцлийг хянах;
  - 5.1.2. арилжаа зохион байгуулах зааврын хэрэгжилтэнд хяналт тавих;
  - 5.1.3. үнэт цаасны арилжаанд оролцогчид нь зах зээлийг урвуулан ашиглах байдлаар хуурамч арилжаа хийж буй эсэхэд тогтмол хяналт тавих;
  - 5.1.4. хяналтын систем дээр үүссэн сэрэмжлүүлэх дохионы дагуу сэжигтэй хэлцлүүдийг дэлгэрүүлэн шалгаж, зөрчилтэй гэж үзсэн хэлцлүүдийг цааш нарийвчлан шалгах;
  - 5.1.5. сэжигтэй хэлцлийн худалдсан, худалдан авсан дансны эзэмшигчид нь нэгдмэл сонирхолтой эсэхийг шалгах.
- 5.2. Хяналт шалгалт хариуцсан нэгж нь энэ журмын 5.1-д заасан хяналтыг тавихаас гадна анхдагч зах зээлийн арилжаа болон багцын арилжаа бусад үнэт цаасны арилжаанд нэгэн адил хяналт тавина;
- 5.3. Хяналт шалгалт хариуцсан нэгж нь дотоод мэдээлэл эзэмшигчдийн сан бий болгож, хяналтын систем ашиглан дотоод мэдээлэл эзэмшигчдэд хяналт тавина.

### 6 дугаар зүйл. Гишүүн үнэт цаасны компанид тавих хяналт шалгалт

- 6.1. Гишүүн үнэт цаасны компанийн дараах үйл ажиллагаанд холбогдох хууль, журмын дагуу тогтмол хяналт тавина:

- 6.1.1. холбогдох хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн хэрэгжилт;
- 6.1.2. гишүүн компани, түүний ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилт;
- 6.1.3. биржийн гишүүнчлэлийн журамд заасан шаардлага, шалгууруудыг ханган ажиллаж байгаа эсэх;
- 6.1.4. холбогдох мэдээ, мэдээллээ тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэх;
- 6.1.5. үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан үйл ажиллагаа явуулсан эсэх;
- 6.1.6. харилцагчийн захиалга хүлээн авах, биелүүлэх үйл ажиллагаа;
- 6.1.7. дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаа;
- 6.1.8. мэргэжлийн оролцогчдын хууль журамд заасан бусад үйл ажиллагаа.

#### 7 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчид тавих хяналт шалгалт

- 7.1. Үнэт цаас гаргагчийн дараах үйл ажиллагаанд холбогдох хууль, журмын дагуу тогтмол хяналт тавина:
  - 7.1.1. холбогдох хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн хэрэгжилт;
  - 7.1.2. Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж байгаа эсэх;
  - 7.1.3. үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх журмыг хэрэгжүүлэн ажиллаж, мэдээллийг олон нийтэд цаг хугацаанд нь хүргэж буй эсэх;
  - 7.1.4. үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн бүртгэл, тайлагнал.

#### 8 дугаар зүйл. Өргөдөл гомдол, мэдээ мэдээлэлд үндэслэсэн хяналт шалгалт

- 8.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгсэн мэдээ мэдээлэл болон иргэд, байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийн дагуу хяналт тавьж, шалгалт хийнэ.
- 8.2. Үнэт цаасны арилжаа, гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллаас ирүүлсэн өргөдөл гомдлыг “МХБ-д иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх заавар”-ын дагуу хянан шийдвэрлэнэ.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ

#### 9 дүгээр зүйл. Хяналт шалгалтын зохион байгуулалт, холбогдох тайлан мэдээ

- 9.1. Хяналт шалгалтыг доорх бүтэц, бүрэлдэхүүнээр хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 9.1.1. хяналт шалгалтын мэргэжилтэн;
  - 9.1.2. хяналт шалгалт хариуцсан нэгж;
  - 9.1.3. хамтарсан ажлын хэсэг.

- 9.2. Хамтарсан ажлын хэсгийг дор дурьдсанаар байгуулна. Үүнд:
  - 9.2.1. Үнэт цаас гаргагчид шалгалт хийх зорилгоор Хорооны дарга, Биржийн Гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар Хамтарсан ажлын хэсгийг тухай бүр байгуулна;
  - 9.2.2. хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь Биржийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн, Хорооны Улсын байцаагчаас бүрдэнэ.
- 9.3. Хяналт, шалгалтын ажлыг дараах хэлбэрээр гүйцэтгэнэ. Үүнд:
  - 9.3.1. Зайны хяналт шалгалт:
    - 9.3.1.1. Гишүүн үнэт цаас цаасны компани болон үнэт цаас гаргагчаас холбогдох хууль журмын дагуу ирүүлсэн баримт, тайлан, мэдээлэл болон бусад мэдээ мэдээлэлд үндэслэн хийх хяналт шалгалт;
    - 9.3.1.2. арилжааны хяналтын систем ашиглан хийх хяналт шалгалт;
    - 9.3.1.3. зайны хяналт шалгалтыг энэ журмын 4.1-д заасан чиглэлийн дагуу Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж тогтмол хэрэгжүүлнэ.
  - 9.3.2. Газар дээрх шалгалт:
    - 9.3.2.1. тогтоосон хуваарь, төлөвлөсөн цаг хугацаанд батлагдсан удирдамжийн дагуу гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчдад төлөвлөгөөт шалгалт хийх;
    - 9.3.2.2. удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хэвлэлийн мэдээ, иргэдийн мэдээлэл, арилжаа хянах явцад илэрсэн зөрчил зэрэг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд гэнэтийн шалгалт хийх;
    - 9.3.2.3. гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн ажлын байранд очиж газар дээр нь хийх шалгалтыг Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж, хамтарсан ажлын хэсэг тус тус хэрэгжүүлнэ.
- 9.4. Энэ журмын 9.3.2-д заасан шалгалтын удирдамжийг Биржийн Гүйцэтгэх захирал батална.
- 9.5. Шалгалтын удирдамжид дараах зүйлүүдийг тодорхой тусгана. Үүнд:
  - 9.4.1. шалгалтын ажлын чиглэл;
  - 9.4.2. шалгалтын зорилго;
  - 9.4.3. шалгалт хийх хугацаа, сунгах нөхцөл;
  - 9.4.4. шалгалт явуулах бүрэлдэхүүн.
- 9.6. Энэ журмын 9.3.2-д заасан шалгалтыг гүйцэтгэж дууссаны дараа санал, дүгнэлт бүхий тайланг ажлын 5 өдөрт гаргаж, Хорооны дарга, Биржийн Гүйцэтгэх захиралд танилцуулна.

- 9.7. Хяналт шалгалтын мэргэжилтэн нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай холбоотой мэдээлэл, захиалгын гэрээ болон бусад шаардлагатай баримт ирүүлэх хугацаатай албан даалгаврыг Гишүүн үнэт цаасны компанид өгнө.
- 9.8. Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдал нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол хувь хүн, хуулийн этгээдийн нууцад үл хамаарах хэсгийг олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.
- 9.9. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагчтай холбоотой эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.
- 9.10. Бирж нь шалгалтын дүнгээр илэрсэн зөрчлийн талаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д заасны дагуу Хороонд нэн даруй мэдэгдэж, шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, түүний нотлох баримт, танилцуулгыг хавсаргаж буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх саналаа хүргүүлнэ.
- 9.11. Зөрчлийн улмаас үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжааг нь зогсоосон болон гишүүн үнэт цаасны компанийн арилжаанд оролцох эрхийг хязгаарласан нь тэдгээрийн хууль, журамд заасан мэдээллээ ил тод болгох болон бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭРГЭЖИЛТНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

10 дугаар зүйл. Хамтарсан ажлын хэсэг, хяналт шалгалтын мэргэжилтний эрх

- 10.1. Хамтарсан ажлын хэсэг дараах эрхтэй байна. Үүнд:
  - 10.1.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, түүнд үндэслэсэн нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын биелэлтэд хяналт тавих, шаардлагатай асуудлыг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулах;
  - 10.1.2 төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтаар илэрсэн зөрчилд акт тогтоох, торгууль тавих, түүний гүйцэтгэлийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг, албан шаардлага өгч, биелэлтийг хангуулах, тухайн зөрчил “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзсэн, эсхүл зөрчсөн нь тогтоогдсон бол энэ журмын 14.1, 14.2-д заасан хариуцлагыг эрх бүхий этгээдийн шийдвэрээр хүлээлгэх;
  - 10.1.3 хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 10.2. Хяналт шалгалтын мэргэжилтэн дараах эрхтэй байна. Үүнд:
  - 10.2.1. хяналт шалгалт хийх байгууллагад саадгүй нэвтрэн орох, шалгалтад шаардлагатай баримт материал, тайлан мэдээллийг зохих этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;
  - 10.2.2. хяналт шалгалтын дүн, зөрчлийн хуудас (Маягт-1)-ыг үндэслэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах талаар хугацаатай үүрэг, албан даалгавар өгөх, гүйцэтгэлийг хангуулах, холбогдох журам болон гэрээнд заасан хариуцлага ногдуулах;



- 10.2.3. хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг ноцтой зөрчсөн гэж үзэх үндэслэл бүхий хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг зогсоох саналыг эрх бүхий этгээдэд гаргах;
- 10.2.4. бусад алба, мэргэжилтнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүмүүсийг шалгалтанд татан оролцуулах, эрх бүхий байгууллагуудтай хамтран шалгалт хийх;
- 10.2.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа үнэт цаасны талаар мэдээлэл гаргуулах;
- 10.2.6. ирүүлсэн тайлан, мэдээг хянах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг тухай бүр авах, шаардлагатай гэж үзвэл шалгалт хийх санал гаргах;
- 10.2.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүний үүрэг

11.1. Хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүн нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

- 11.1.1. шалгалтыг бодит баримт нотолгоонд үндэслэн явуулах, бусдын нөлөөнд автахгүй байх;
- 11.1.2. нийтэд тараагдаагүй болон шалгалттай холбоотой мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, шалгаж буй асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргах, мэдээлэл хийх, шалгалтын баримт мэдээллийг бусад зорилгоор ашиглахгүй байх;
- 11.1.3. шалгалт нь өөрийн ашиг сонирхолд шууд хамааралтай болон шалгагдаж буй этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол энэ тухай эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, шалгалт хийхээс татгалзах, хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс нэрээ татах;
- 11.1.4. хяналт шалгалтын ажлын тайлан болон түүний хавсралт баримт бичиг, мэдээ мэдээллийн анхны хэлбэрийг алдагдуулахгүйгээр тэмдэг, лац, гарын үсгээр баталгаажуулан хадгалах;
- 11.1.5. шалгалтын эцсийн дүгнэлт, тайлан, зааварчилгаа, сэрэмжлүүлэг, ажлын баримт, нотолгооныхоо үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 11.1.6. хяналт шалгалтын мэргэжилтэн нь Биржийн Гүйцэтгэх захирлын шийдвэрийн дагуу олгогдсон үнэмлэх, тэмдэг хэрэглэх;
- 11.1.7. хяналт шалгалтын мэргэжилтний үнэмлэхийг бусдад шилжүүлэхгүй байх, хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх.

12 дугаар зүйл. Хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүнд хориглох үйл ажиллагаа.

12.1. Хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүнд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- 12.1.1. шалгалтын материал, баримт бичиг, мэдээ мэдээллийг бусдад зөвшөөрөлгүйгээр тараах, дамжуулах, өөр зорилгоор ашиглах;

- 12.1.2. шалгалтанд хувийн сонирхлоор хандах, шалгуулж буй этгээдээс бэлэг, мөнгө, шагнал болон өөрт ашигтай аливаа туслалцаа авахгүй байх, ажил үүргийн хуваарьт хамаарахгүй баримт материал шаардах;
- 12.1.3. шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэх;
- 12.1.4. удирдамжид тусгагдаагүй асуудлаар шалгалт явуулах, удирдах болон гүйцэтгэх албан тушаалтантай зохисгүй харьцах, айлган сүрдүүлэх;
- 12.1.5. шалгалтын талаар эцсийн дүгнэлт гараагүй байхад олон нийтэд мэдээлэх, бусдын нэр хүндэд халдах.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ЗӨРЧЛИЙН ТӨРЛҮҮД, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

### 13 дугаар зүйл. Зөрчлийн төрлүүд

13.1. Шалгалтын дүнгээр дараах зөрчил илэрвэл хяналт шалгалтын мэргэжилтний тогтоосон зөрчлийн хуудас, хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн энэхүү журмын 13 дугаар зүйлд заасан хариуцлагыг ногдуулна. Үүнд:

13.1.1. Үнэт цаасны арилжаатай холбогдох дараах зөрчлүүд:

- 13.1.1.1. үнэт цаасны үнэ ханш /нээлт, хаалт, дээд, доод ханш/-ийг зохиомлоор тодорхой түвшинд барих, өсгөх, бууруулах үйлдэл хийсэн;
- 13.1.1.2. үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тодорхой түвшинд барих, өсгөх, бууруулах зорилгоор үнэт цаасны арилжааны явцад цөөн тоо ширхэгээр, ханшийн өөрчлөлттэй гүйлгээг удаа дараа хийсэн;
- 13.1.1.3. үнэ ханшид нөлөөлөх зорилгоор зах зээлтэй холбоотой худал, буруу мэдээллийг олон нийтэд тараасан;
- 13.1.1.4. дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд нь бүртгэлтэй үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцсон;
- 13.1.1.5. дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, нийтэд болон гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулсан;
- 13.1.1.6. бусдын нэрийн өмнөөс болон өөрийн нэрийн данс ашиглан үнэт цаасны арилжаа, мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийсэн;
- 13.1.1.7. хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэнд хяналт шалгалттай холбоотой баримт, материал гаргаж өгөхөөс татгалзсан;
- 13.1.1.8. тухайн өдрийн арилжаанд, эсвэл тодорхой хугацааны туршид нэг үнэт цаасыг өндөр /бага/ үнээр худалдан авсны дараа бага /өндөр/ үнээр худалдах үйлдлийг давтан үйлдсэн, ийм захиалгыг харилцагчаас хүлээн авч биелүүлсэн;
- 13.1.1.9. биелүүлэх зорилгогүйгээр их хэмжээний захиалга шивсэн, түүнд олон дахин засвар оруулах, татаж авах, нэг захиалгыг олон хэсэг хувааж шивэх үйлдэл хийсэн;
- 13.1.1.10. харилцагчдад худал буруу мэдээлэл өгөх, тэдгээрийг ятгах төөрөгдүүлэх, харилцагчийн захиалгыг биелүүлэхээс өмнө

мэдээллийг тараах, захиалгыг орхигдуулах, харилцагчийн зөвшөөрөлгүй болон харилцагчид хохиролтой гүйлгээ хийх, захиалгын үнэ тоо ширхэгийг өөрчлөх, мөнгөн хөрөнгийг ашиглах;

- 13.1.1.11. харилцагчийн өгсөн үнэт цаас худалдах болон худалдан авах захиалгын нөхцлийг /захиалгын тоо ширхэг, үнэ, төрөл, хүчинтэй байх хугацаа/ санаатай болон болгоомжгүй байдлаар өөрчлөн системд оруулсан;
- 13.1.1.12. мэргэжлийн оролцогчийн уруутай ажиллагааны улмаас захиалга өөрчлөгдсөн, эсхүл цуцлагдсан тохиолдолд журмын 14.1.1-д заасны дагуу сануулах арга хэмжээ авах, удаа дараа давтагдсан бол мэргэжлийн оролцогчийн арилжаанд оролцогчийн эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авна;
- 13.1.1.13. алсаас арилжаанд оролцох эрхтэй гишүүн нь системд нэвтрэх эрхээ бусдад дамжуулах болон ашиглах боломжийг санаатай буюу болгоомжгүй байдлаар олгосон;
- 13.1.1.14. хяналт шалгалтын мэргэжилтний албан даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй, арилжааны дэгийг удаа дараа зөрчсөн, анхан шатны болон санхүүгийн холбогдолтой баримтыг зохих журмын дагуу бүрдүүлээгүй, тайлан мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаагүй;
- 13.1.1.15. анхан шатны баримтыг буруу, дутуу хөтөлсөн, хуурамчаар бүрдүүлсэн;
- 13.1.1.16. шалгалтын ажилд шаардлагатай баримт материал гаргаж өгөөгүй, шалгалтын ажилд саад учруулсан;
- 13.1.1.17. арилжаа шударга явагдах нөхцөл болон харилцагчийн эрх ашгийг зөрчсөн бусад үйлдлүүд хийсэн;
- 13.1.1.18. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78, 80 дугаар зүйл, Хорооны “Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журам”-ыг зөрчсөн.

13.1.2. Гишүүн үнэт цаасны компанийн үйл ажиллагаатай холбогдох дараах зөрчлүүд:

- 13.1.2.1. өөрийн хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон хэмжээг хангахгүй нь тогтоогдсон;
- 13.1.2.2. үйл ажиллагааны эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгө нь тогтоосон хэмжээнд хүрэхгүй нь тогтоогдсон;
- 13.1.2.3. ажлын байр, техник, тоног төхөөрөмж, боловсон хүчин нь холбогдох журам, гэрээнд заасан шаардлага хангахгүй;
- 13.1.2.4. зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм, журмыг мөрдөж ажиллаагүй;
- 13.1.2.5. гишүүнчлэлийн журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
- 13.1.2.6. холбогдох мэдээ, мэдээллээ тогтоосон хугацаанд ирүүлээгүй;

13.1.2.7. үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчийн үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам зөрчсөн.

13.1.3. Үнэт цаас гаргагчтай холбогдох дараах зөрчлүүд:

13.1.3.1. үнэт цаас гаргагч нь Биржийн Бүртгэлийн журамд заасан бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

13.1.3.2. үнэт цаасны холбогдох ангиллын шалгуурыг хангахгүй болсон; үнэт цаасны хөрвөх чадвар алдагдсан;

13.1.3.3. мэдээ мэдээллээ хугацаанд нь ирүүлээгүй

13.1.3.4. давхар бүртгэлтэй биржийн бүртгэлээс тухайн үнэт цаас нь хасагдсан;

13.1.3.5. үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчийн үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам зөрчсөн.

13.1.3.6. өрийн хэрэгслийн хувьд үндсэн болон хүүгийн төлбөр хугацаандаа төлөгдөөгүй.

14 дүгээр зүйл. Хариуцлага хүлээлгэх

14.1. Гишүүн үнэт цаасны компани нь хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан, энэ журмын 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаагүй, 13.1.2-д заасан зөрчил гаргасан нь хяналт шалгалтын мэргэжилтний дүгнэлт, зөрчлийн хуудсаар тогтоогдвол дараах хариуцлагын аль нэгийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр хүлээлгэнэ. Үүнд:

14.1.1. Сануулах;

14.1.2. Гэрээний хариуцлага ногдуулах;

14.1.3. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах;

14.1.4. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх;

14.1.5. Гишүүний эрхийг цуцлах;

14.1.6. Гишүүний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх санал хүргүүлэх;

14.1.7. Гишүүний тусгай зөвшөөрлийг цуцлуулах санал хүргүүлэх.

14.2. Үнэт цаас гаргагч нь хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан, энэ журмын 7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаагүй, 13.1.3-д заасан зөрчил гаргасан нь хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн дүгнэлт, зөрчлийн хуудсаар тогтоогдвол дор дурьдсан хариуцлагын аль нэгийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр хүлээлгэнэ. Үүнд:

14.2.1. сануулах;

14.2.2. гэрээний хариуцлага ногдуулах;

14.2.3. үнэт цаасны арилжааг зогсоох;

14.2.4. үнэт цаасны ангилал бууруулж бүртгэх;

14.2.5. үнэт цаасыг бүртгэлээс хасах;

- 14.2.6. нэмж үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой эрхийг хязгаарлах.
- 14.3. Бирж хариуцлага ногдуулах тухай шийдвэрт уг шийдвэрийн үндэслэлийг тодорхой заасан байна.
- 14.4. Хяналт шалгалтаар үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компани хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасны улмаас зохих арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн тухай шийдвэрийг Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 14.5. Үнэт цаасны арилжааг зогсоох, арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, цуцлах тухай шийдвэрийн үндэслэл болсон нөхцөл, шалтгаан арилсан гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компани нь эдгээр эрх, зөвшөөрлийг сэргээх тухай хүсэлтээ сэргээх үндэслэл, нотлох баримтын хамт Биржид ирүүлнэ.
- 14.6. Бирж нь үнэт цаасны арилжааг зогсоох, арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах нөхцөл, шалтгаан арилсан гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компаниас хүсэлт ирүүлсэн эсэхээс үл хамааран арилжааг сэргээж болно.
- 14.7. Гишүүн компани, Үнэт цаас гаргагч нь хяналт шалгалтын мэргэжилтний тогтоосон зөрчлийн хуудсыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох эрх бүхий этгээдэд гомдол гаргаж болно.
- 14.8. Хариуцлага хүлээгч нь Биржийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол дээд шатны байгууллага, албан тушаалтанд 10 хоногийн дотор гомдол гаргаж болно.
- 14.9. Хяналт шалгалтын мэргэжилтэн, Хамтарсан ажлын хэсгийн гишүүд энэхүү журмын 10 дугаар зүйлд заасан эрхээ хэтрүүлсэн буюу урвуулан ашигласан, 11 дүгээр зүйлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, 12 дугаар зүйлд заасан хориглох үйл ажиллагаа явуулсан бол Биржийн "Хөдөлмөрийн дотоод журам", "Хөдөлмөрийн гэрээ"-ний дагуу сахилгын шийтгэл ногдуулна.